

Цэндийн Баттулга¹, Басандоржийн Буян-Орших²¹Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Ази судлалын тэнхим²“Mapss” төслийн гэрээт судлаач

Тэвшийн руни бичээсүүд

Товчлол. Тус өгүүлэлд Өвөрхангай аймгийн Богд сумын төвөөс 20 гаруй км-т орших Тэвш уулнаас илрүүлж тэмдэглэсэн ч судалгааны эргэлтэд ороогүй өнөөг хүрсэн нэг мөр руни бичээс болон шинээр илрүүлсэн 2 бичээсийг танилцуулж байна. Уг бичээсийг А.П.Окладниковын удирдсан хээрийн шинжилгээний анги 1948, эсвэл 1962 оны аль нэгэнд илрүүлсэн бололтой. Бичээсийг хуулсан гар хуулбарт $\mathfrak{b}\mathfrak{a}\mathfrak{n}$ бн, $\mathfrak{q}\mathfrak{a}\mathfrak{r}\mathfrak{a}\mathfrak{b}\mathfrak{o}\mathfrak{d}\mathfrak{u}\mathfrak{n}\mathfrak{a}$ qara boduna – харц ард гэсэн үгс маш тодорхой байгаа боловч бүрэн хуулбар биш тул өөр ямар үг байгаа, ямар агуулгатайг тодорхойлох боломжгүй байна. Бичээсийг хурц үзүүртэй багаж зэвсгээр зурж бичсэн, руни бичгийн дурсгалын зураасан бичээсийн төрөлд хамаарах дурсгал юм.

Түлхүүр үг. Өвөрхангай аймаг, Богд сум, Тэвш уул, руни бичиг

Battulga Tsend¹, Buyan-Orshikh Basandorj²¹Department of Asian Studies, Faculty of Humanities, School of Arts and Sciences,

National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

²Contract researcher of Mapss

The runic inscriptions of Tevsh mountain

Abstract. The article introduces a single line of runic inscriptions that have been discovered and documented on Mount Tevsh, situated at a distance exceeding 20 km from the center of Bogd Soum in Övörkhangaï Province. However, this particular line is unstudied, and two another inscriptions have just been found. The inscription was apparently unearthed in either 1948 or 1962 by a field research team under the leadership of A.P.Okladnikov. The words $\mathfrak{b}\mathfrak{a}\mathfrak{n}$, meaning ‘I’, and $\mathfrak{q}\mathfrak{a}\mathfrak{r}\mathfrak{a}\mathfrak{b}\mathfrak{o}\mathfrak{d}\mathfrak{u}\mathfrak{n}\mathfrak{a}$ qara boduna, meaning ‘common people’, are evident in the text from which the inscription was transcribed. However, due to its incomplete nature, it is not feasible to ascertain the presence of further words and their respective meanings. The inscriptions are written with sharp tools and belong to the type of incised inscriptions.

Keywords. Övörkhangaï province, Bogd soum, Mount Tevsh, runic inscription

Удиртгал

Сүүлийн жилүүдэд Монголын руни бичгийн дурсгалын бүртгэл харьцангуй бүрэн болж судалгаа ч улам нарийсан гүнзгийрч байгаа билээ. Гэвч олон жилийн өмнө ном бүтээлд хэвлэгдэж судалгааны эргэлтэд орсон зарим нэг бичээсийг өнөө хүртэл үзэж шалгасан, уншиж судалсан зүйл хараахан үгүй бололтой бөгөөд тэдгээрийн нэг нь Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын руни бичээс юм. Тус бичээс нь 1980 онд хэвлэгдсэн “Петроглифы Центральной Азии. Кобд-Сомон (Гора Тэбиш)” хэмээх номд хуулбар нь хэвлэгджээ. Тус бичээс нь өнөө хэр судалгааны эргэлтэд ороогүй байна. Бид тус бичээсийг нягтлах дахин баримтжуулах зорилгоор 2023 оны намар явсан боловч хараахан олоогүй болно.

Харин тухайн дурсгалт газар хоёр руни бичгийн дурсгалыг шинээр илрүүлсэн юм (*Зураг 1, 2*).

Судалгааны байдал

Тэвш уулын хадны зургийн тухай эрдэмтэн А.П.Окладников Тэвшийн хадны зургийг 1949, 1962, 1976 онуудад тухайлан судалж эрдэм шинжилгээний олон өгүүлэл хэвлүүлж байсан бөгөөд улмаар 1980 онд “Петроглифы Центральной Азии. Кобд-Сомон (Гора Тэбиш)” хэмээх ном хэвлүүлсэн байна [Окладников, 1980: 52].

Б.Ринчен академич 1968 онд бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлснээр шинжлэх ухааны эргэлтэд орсон байна [Rintchen, 1968: 43].

1977 онд МЗТСХЭ Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд Хүннүгийн жирийн иргэдийн

булш малтан судалсан байна [Цэвээндорж, 1977: 208].

Н.Сэр-Оджав гуай Тэвшийн бичээсийн анх оршиж байсан газрынх нь тухай “Өвөрхангай аймгийн Богд (хуучнаар Ховд) сумын төвөөс 20 орчим км-ын зайд орших Тэвш гэдэг баруун зүүн тийш хөндөлдсөн хавтгай нурууны өвөрт байсан” [Сэр-Оджав, 1977: 141] гэж тэмдэглэжээ. Н.Сэр-Оджав гуай уг бичигт чулууг Улаанбаатар хотод авчирсан бөгөөд эдүгээ ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа билээ.

Түрэг судлаач В.М.Наделяев 1974 онд бичээсийн нэг мөрийг “Тугчы бургуцы Ягыз чурын тамга” гэж уншиж судалгааны эргэлтэд оруулсан бөгөөд тамгыг Ягыз чурын овгийн тамга гэж үзсэн байна [Наделяев, 1974: 136-150].

С.Харжаубай 1979 онд “Тэвшийн бичээс”-ийг дахин нягтлан судалж, бичээсийг 1. Tugčim uragači Yagiz- čur tug ötü 2. tugči bu... гэж үгчлэн галиглаад 1. хэнгэрэгч минь, уриач /дуудагч/ Ягыз-чур хэнгэргээ дуугарган /хангинуулан/...2. Хэнгэрэгч энэ [Харжаубай, 1979: 33] гэж орчуулжээ.

Академик Л.Болд 1990 онд хэвлүүлсэн бүтээлдээ С.Харжаубайн судалгааг дурдаад В.М.Наделяевын уншлагыг [Болд, 1990: 110-112] хожим “Орхон бичгийн дурсгалууд II” бүтээлдээ мөн судалгааны галигийг хэвээр нь авч, бичээсийг “tugči burguči yagiz čur tugragi” гэж галиглаад, “тугч, бүрээч Ягыз-чур (хаан)-ны тамга” [Болд, 2000: 237] гэж орчуулсан байна.

Ц.Баттулга 2005 [Баттулга, 2005: 117], 2022 ондууд хэвлүүлсэн бүтээлдээ “Тэвшийн бичээс”-ийг уншиж судалсан үр дүнгээ танилцуулжээ. Судалгааг толилуулбал, бичээсийн эхийн сийрүүлэг: $\text{N}|\text{H}|\text{Y}|\text{A}|\text{H}|\text{D}|\text{L}|\text{H}|\text{D}|\text{S}|\text{L}|\text{H}|\text{A}|\text{.}2$ [$\text{Y}|\text{X}|\text{I}|\text{D}|\text{L}|\text{H}|\text{A}|\text{.}1$

Үгийн галиг: 1. tugči boltim äsid[in] 2. tugči burguči yagiz čur tugragi

Орчуулга: 1. Тугч болов би. Сонсогтун. 2. Тугч бүрээч Ягыз чурын тамга [Баттулга, 2022: 190-192]. Энэхүү судалгаа нь одоогоор Тэвшийн бичээсийн талаарх хамгийн сүүлийн судалгаанд зүй ёсоор тооцогдож байна.

Тэвшийн судлагдаагүй бичээс

Л.Болд гуай 1986 онд хэвлүүлсэн “БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал” [Болд 1986: 65-87] хэмээх өгүүлдэдээ “Тэвшийн түрэг бичээс II” гэж бүртгэсэн байдаг. Ц.Баттулга 2005 онд хэвлүүлсэн номынхоо “нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал” гэсэн хэсэгт “Тэвшийн бичээс II. Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг, Тэвш уулнаас олсон бололтой. Одоогоор уул бичээсийн талаар өгүүлэх тодорхой

баримт бидэнд үгүй байна” [Баттулга, 2005: 108] гэж тэмдэглэжээ.

Хурц үзүүртэй багаж зэвсгээр зурж бичсэн бичээсийг дарж морь зурсан байх бөгөөд морины зураасан зургийг дарсан олон сараачмал зураас буйг зургийн гар хуулбараас тодорхой харагдана [Окладников, 1980: 52] (Зураг 3).

Тэдгээр морины зураг, сараачмал зурааснаас салгаж, бичээсийг тусад нь сийрүүлсэн байх боловч бүрэн унших боломжгүй юм (Зураг 4).

Тэвшийн бичээсийг А.П.Окладников абугайн гар зурагт тулгуурлан бичээсийн эхийг тоймлож сийрүүлбэл:

... $\text{D}|\text{H}|\text{Y}|\text{S}|\text{S}|\text{S}|\text{S}|\text{H}|\text{H}|\text{I}|\text{A}|\text{H}|\text{A}$

Үсгийн галиг: b n b i Q R A B W D a l ü a Y

Үгийн галиг: bän bi? qara boduna ...

Орчуулга: би ... харц ард ...

Гар хуулбар зурагт тэмдэглэгдсэн үсгийг буулгаж дээрх мэт уншиж болохоор байна. Бичээс юутай ч $\text{H}|\text{A}|\text{H}|\text{A}$ bän- Би гэх үгээр эхэлж байгаа нь лавтай байна.

Энэ өгүүлбэрийн дунд хавьд $\text{S}|\text{S}|\text{S}|\text{S}|\text{H}|\text{H}|\text{I}|\text{A}|\text{H}|\text{A}$ qara boduna – Харц ард гэсэн үг багтай байх ба тун тодорхой тэмдэглэгджээ. Гар хуулбараас үзвэл ганц мөр бичээс байсан бололтой. Мөн бичээст холбогдох тамга байсан эсэх нь тодорхойгүй байна.

Бид дээрх бичээсийг нягтлах, дахин баримтжуулах зорилгоор 2023 оны намар явсан боловч хараахан олоогүй болно. Харин тухайн дурсгалт газар хоёр руни бичгийн дурсгалыг шинээр илрүүлсэн юм. Шинээр илрүүлсэн Их Дуутын бичээст $\text{S}|\text{S}|\text{S}|\text{S}|\text{H}|\text{H}|\text{I}|\text{A}|\text{H}|\text{A}$ qara bodun – харц ард, харц ард иргэд гэж тэмдэглэгдсэн нь тухайн үед бичээс хуулсан цаасан дээр хадны зургийг, эсвэл хадны зураг хуулсан цаасан дээр бичээсийг давхардуулж хуулсан байх магадлалтайг тэмдэглэе.

Монголын антропологи, археологи, угсаатан судлалын сэтгүүл (ISSN1810-5025)-д [Баттулга, 2024: 109-115] Их дуут болон Хүрмэн хадны шинээр илрүүлсэн бичээсийг уншиж тайлсан тухайлсан судалгаа хэвлэгдсэн тул доор хураангуйлан өгүүлэв.

Их Дуутын бичээс

Өвөрхангай аймгийн Богд сумын Баянтөхөм багийн нутаг, Бага Тэвш (уг нэр нь Тэгш)-ийн уулын зүүн өмнө бэлд, хуучин Богд сумын төвийн харалдаа ард их, бага Дуут буюу заримдаа бас баян Тэвш ч гэх саахалтын зайтай хоёр өвөлжөө бий.

Саахалт хоёр өвөлжөөний баруун талыг Их Дуутын өвөлжөө гэх бөгөөд өвөлжөөний энгэр бэл, хормойн хад чулуунд хүрлийн үед холбогдох

хадны зураг ихтэй.

Өвөлжөөнөөс нэлээд зайдуу, баруун хойно хүрмэн чулуунд гурван мөрөөр бичсэн руни бичээс шинээр илрүүлэв. Бичээсийг хүрэн бор өнгөтэй, ургаа хүрмэн чулууны өмнө зүг харсан толигорт хурц үзүүртэй багаж зэвсгээр тиг хэлбэр сайтай тун чадамгай, маш нарийн зурж бичжээ.

Бичээсийн нэгдүгээр мөрийг чулууны оройгоос 16 см доор, чулууны зүүн ирмэгээс 2 см зайтай бичжээ. Мөрийн урт 10.5 см, 8 үсэгтэй, үсгийн өндөр 8-12 см. Хоёрдугаар мөрийг хадны зүүн ирмэгээс 3 см зайтай бичсэн байна. Мөрийн урт 15.5 см, 13 үсэгтэй, үсгийн өндөр 6-10 см. Гуравдугаар мөрийг хадны зүүн ирмэгээс 12 см зайтай бичсэн байна. Мөрийн урт 17.5 см, 14 үсэгтэй, үсгийн өндөр 5-10 см (Зураг 5).

Бичээст шууд болон дам холбогдох тамгагүй. Гэхдээ өвөлжөөний баруун хойд энгэрийн хаданд нэг хоёроор, бас нэгжгээдийг зэрэгцүүлж сийлсэн, Уйгурын үед холбогдох тамга цөөн боловч буйг тэмдэглэе.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨ.1
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ.2
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ.3

Үсгийн галиг:

1. b n b ᠠ B ᠸ i
2. Q R a B W D N Q a b ü k a
3. T W T m s Y G i Y W Q r m s

Үгийн галиг:

1. bān bān abīcī
2. qara bodunqa bökä
3. tutmiš yaγi yoq ārmiš

Үгчилсэн орчуулга:

1. Би Бэнг Абици
2. харц ардад бөхлөн
3. захирчээ. Дайсан үгүй болжээ

Утгачилсан орчуулга: Би Бэнг Абици. Харц ард иргэдийг бөхлөн [чандлан] захирав. Дайсангүй болов.

Бичээст ард олны үймээн, бослого хөдөлгөөнийг дарж, дотоодын дайсангүй болсон түүхэн үйл явдлыг тэмдэглэж үлдээсэн бололтой байна.

Руни бага бичгийн дурсгалуудад, ялангуяа Енисейн бичээст тогтсон нэг загварын *ār atim* -эр нэр минь, цэрэг нэр минь, эрэлхэг, баатар нэр минь гэх буюу эсвэл *atim* - миний нэр гээд өөрийн өргөмж цол, алдар нэрээ дурдах найруулга зонхилдог.

Тус бичээст *ᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨ* bān bān abīcī- Би Бэнг Абици гэж өөрийн өргөмж цол, алдрыг дурдаагүй нь тогтсон уламжлалт найруулгаас ялгарч байна.

Бичээсийг бичигч Бэнг Абици (*ᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨ* bān abīcī) бол “Харц ард иргэдийг бөхлөн [хатуу чанга] захирч, дайсангүй болгосон” цэргийн эрх мэдэлт язгууртан түшмэл гэдэг нь эргэлзээгүй. Өргөмж цол, алдар нэрээ тоочиж дурдаагүйгээс үзвэл, бичээчийн хувьд “харц ард иргэдийг бөхлөн [чандлан] захирч дайсангүй болгох” үүрэг даалгаврыг амжилттай биелүүлснээ тэмдэглэх нь чухал байсан бололтой. Үг үсэг болон уншлагад хамаарах эргэлзээтэй зүйл бичээст огт үгүй байна. Гэвч Бэнг Абици (*ᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨᠪᠠᠨ* bān abīcī) нэрийн хоёр дахь үгийг *baᠸi*- Бачы гэж бас уншиж хувилбар байх боломжтойг тэмдэглэе.

Холбогдох тамгагүй, бичгийн тигийг ялган таних онцлог үсэг тэмдэгтгүй боловч Их Дуутын бичээсийг он цагийн хувьд Уйгурын үед холбогдох болов уу хэмээн үзэж байна.

Хүрмэн хадны бичээс

Бид 2023 оны 10-р сард Өвөрхангай аймгийн Богд сумын Баянтөхөм багийн нутаг, Бага Тэвшийн Адуун хүрээний эхэнд, уулын оройг ирмэглэн тогтсон байц хүрмэн хаданд хоёр мөр бичээс байсныг илрүүлсэн билээ.

Бичээс бүхий хаданд том эвэртэй, урт сахалтай, ид загссан янгирын тэхийг баруун зүг хандуулж зурсан байх бөгөөд уг тэхийг эгц өмнөөс нь нум сумаар харван онож буйгаар дүрсэлжээ. Янгирын тэхийн ард ишиг, борлон (1-2 настай) бололтой эвэр нь ургаж буй байдалтайгаар бага насны янгирыг мөн баруун зүг хандуулан дүрсэлсэн байна. Он цагийн хувьд хүрлийн үед холбогдох уг зургийн дээр хоёр мөр бичээсийг хадны өнгөн хэсгийг холцруулан цохих аргаар бичжээ.

Хоёр мөрөөс бүтэх тус бичээсийг 130 см өндөр хадны баруун өмнө зүг харсан бор хүрэн өнгөтэй, хүрмэн хадны толигорт хоёр мөр руни бичээсийг хадыг холоос хээлж эрээлсэн байдалтай харагдахаар урлан бичжээ (Зураг 6).

Бичээсийн нэгдүгээр мөрийн урт 28 см, үсэг тэмдэгтийн өндөр 5~8 см, хоёрдугаар мөрийн урт 18 см, үсэг тэмдэгтийн өндөр 6~8 см.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ᠪᠳᠵᠢᠮᠰ.1
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ.2

Үсгийн галиг:

1. b d z m s
2. Q W T L G ᠸ W R

Үгийн галиг:

1. bādizmis
2. qutluy ᠸur

Орчуулга:

1. урлав
2. Кутлуг чур

Янгирын авлаж буйг дүрсэлсэн хүрлийн

үеийн зургийн дээд талд 𐰃𐰆𐰏𐰐𐰑 qutluy čur гэж бичихэд хадны ирмэгт тулсан учир 𐰃𐰆𐰏𐰐𐰑 bädizmis гэх үгийг түүний дээр бичсэн бололтой. Хаданд байх байрлалаараа нэг, хоёрдугаар мөр мэт харагдавч 𐰃𐰆𐰏𐰐𐰑 qutluy čur bädizmis - Кутлуг чур урлав гэсэн нэг өгүүлбэр юм.

Зураасан бичээсийг бичихтэй адил хурц үзүүртэй багажаар зурсан бус, сонгодог бичгийн адил гүнзгий ухаж сийлээгүй, хээ угалз байдлаар урлаж бичсэнээ онцолж, товойлгон илэрхийлэхийн тулд 𐰃𐰆𐰏𐰐𐰑 bädizmis - урлав, чимэглэв, урлажээ, чимэглэжээ гэх үгийг сонгон авсан бололтой.

Монголын руни бичгийн бага дурсгалд анх удаа урлах, хээлэх, чимэглэх гэх үгээр “урлан бичив, хээлэн бичив” гэсэн утга санааг илэрхийлж “бичив” гэдэг үгийг хэрэглээгүй байна. 𐰃𐰆𐰏 bädiz нь хээ, угалз, чимэг гэсэн утгатай. Түрэг, Уйгурын үеийн тахилын онгоны сүмийн хээ чимэглэл, гэрэлт хөшөө, мэлхий чулуун суурь, хүн чулуу, тахилын хавтан, арслан, хонь зэрэг чулуун урлалыг руни бичгийн дурсгалд *bädiz* гэдэг, харин түүнийг урлагч урчуудыг *bädizci* гэнэ.

Хүрмэн хад хэмээх бичээс бүхий энгэрээс Тэвш уулын өмнө, баруун өмнө этгээдээс Арцатын нурууг бэллэж, Ховд гол, Элгэн булаг, цаашлан Их Богдын бэлээр явах гол зам алган дээр тавьсан мэт харагдана. Газрын энэхүү онцлог байршил, байрлалаас харахад толгойн сэргийлэх, харуул манааны алба гүйцэтгэж байсан Кутлуг чур хэмээгч Хүрэмт хаданд бичээс бичсэн бололтой.

Бичээст шууд холбогдох тамга байхгүй боловч Карлук аймгийн тамгыг бичээсээс нэлээд зайтай сийлж үлджээ. Нэг цаг үеийн дурсгал мөн эсэхийг тогтоох боломжгүй ч юутай Карлук аймгийн цэрэг, захирагч энд ирсэн, байсныг тэмдэглэн үлдээжээ. Хүрмэн хадны бичээсийн 𐰃 Т болон бусад үсэг тэмдэгтийн тигээс ажиглахад, он цагийн хувьд Уйгурын үед холбогдох нь тодорхой байна.

Дүгнэлт

Бид дээрх өгүүлэлд Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш ууланд буй руни бичээсний уншлагыг урьдчилсан байдлаар танилцуулж байна. Эхний бичээс нь анх судлаач А.П.Окладников анх руни бичээсний гар зураг хуулбарыг хэвлүүлжээ. Дээрх бичээсийг бид нягтлах, дахин баримтжуулах зорилгоор Тэвш ууланд очсон боловч хараахан олоогүй болно. Тиймээс А.П.Окладников аругайн хуулбарт тулгуурлан эхний байдлаар уншсан. Мөн бичээсийн эх хувийг бид дараа дараагийн судалгаагаар дахин баримтжуулах болно.

Харин дээрх бичээснээс өөр шинэ бичээс олсон нь руни бичгийн судалгааг дахин нэг шинэ эх хэрэглэгдэхүүнээр баяжуулж байна. Хоёр

шинэ бичээсийг судалгааны эргэлтэд оруулснаар цаашид бүс нутгийн түүх соёлын дурсгалын цар хүрээ, харилцан хамаарал зэргийг тодруулахад чухал ач холбогдолтой мэт.

Он цагийн хувьд Их дуутын бичээс болон Хүрмэн хадны бичээс зэрэг нь бичгийн утга агуулгын хувьд Уйгурын үед хамаарч байна.

Ном зүй

Баттулга, 2005 - Ц.Баттулга., Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар.

Баттулга, 2022 - Ц.Баттулга., Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа. Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал, Боть II, Улаанбаатар.

Болд, 1986 - Л.Болд., БНМАУ-д эртний түрэг бичгийн дурсгалыг судалсан байдал, -Шинжлэх Ухааны Академийн мэдээ, Улаанбаатар

Болд, 1990 - Л.Болд., Тэвшийн бичээс // БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар.

Болд, 2000 - Л.Болд, Тэвшийн Орхон бичээс, // Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар.

Наделяев, 1974 - Н.М.Наделяев., Древнетюркская надпись из Ховд сомона МНР, -Бронзовой и железный век Сибири, Ленинград.

Окладников, 1980 - А.П.Окладников., Петроглифы Центральной Азии, Ленинград.

Сэр-Оджав, 1970 - Н.Сэр-Оджав., Монголын эртний түүх. Улаанбаатар.

Харжаубай, 1979 - С.Харжаубай., Эртний гурван бичээс, -*Studia Archaeologica*, Tom. VII, fasc.10-18. Улаанбаатар.

Цэвээндорж, 1999 - Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх, Улаанбаатар, 1999.


Цэвээндорж, 1977 - Д.Цэвээндорж. 1977 онд МЗТС-ын хамтарсан экспедицийн “Нүүдэлчдийн дурсгал судлах” ангийн тайлан // Монголын археологи: Хээрийн судалгааны ангийн тайлан 1975-1978. Улаанбаатар. 208-209

Rintchen, 1977 - Rintchen, Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -*Corpus Scriptorum Mongolorum*, Tom. XVI, fasc I, Улаанбаатар (Oulan bator).



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.


See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.



Зураг 1. Тэвш уулын дэвсгэр зураг



Зураг 2. Тэвш уулын хадны зураг



711(0555)M P 355) 335544 1855


0930-29

Зураг 3. Тэвийн бичээс болон сараачмал морины зургийн хуулбар.
Зураг А.П. Окладников.

711(0555)M P 355) 335544 1855

0930-29

Зураг 4. Тэвийн бичээсийн хуулбар. Зураг А.П. Окладников.



Зураг 5. Их Дуутын бичээсний гэрэл болон гар зураг



Зураг 6. Хүрмэн хадны бичээсний гэрэл болон гар зураг